

**“МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 08 өдөр

№ 1/08

Улаанбаатар хот

Өмч хамгаалах зөвлөлийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус компанийн “Өмч хамгаалах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга:	Захиргааны газрын дарга
Гишүүд:	Захиргааны ахлах мэргэжилтэн
	Ахлах хуульч
	Үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч
	Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн
	Хотхоны менежер
	Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Эрх зүйч


2. Тус компанийн “Өмч хамгаалах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

3. Тус компанийн үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг эзэмших талаарх материалыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлж, улсын бүртгэлд бүртгүүлэх, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, бүртгэгдсэн үндсэн хөрөнгийг шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах, устгах талаар дүгнэлт, санал гаргаж, биелэлтийг зохион байгуулах, тайлагнах ажлыг зохион байгуулахыг тус Зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.АЛТАНЦЭЦЭГ





"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨХХК-ИЙН ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хариуцах нэгж, гишүүний нэр	Хэрэг- жүүлэх хугацаа
1	"МГТБҮ" ТӨХХК-ийн ("Компани" гэх) өмчлөл/эзэмшлийн эд хөрөнгийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, харуул хамгаалалт, ашиглалтын үр ашгийг сайжруулах, "Терийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ	Компанийн өмч хамгаалах үйл ажиллагаа тогтвортойжсон байх	ӨХЗ-ийн дарга, гишүүд	Тухай бүр
2	"МГТБҮ" ТӨХХК-ийн 2023 оны жилийн худалдан авалтын төлөвлөгөө тусгагдсан эд хөрөнгийн тоо хэмжээ, үнийн дээд хязгаар, техникийн болон бусад шаардлагын талаар зөвлөмж гаргана	Тухайн жилийн худалдан авалтын үйл ажиллагаа төсөвт өртийн хэмжээнд байх	ӨХЗ-ийн дарга, гишүүд СЭЗГ	Тухай бүр
3	Компанийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, түүний үр ашгийг дээшлүүлэх талаар арга хэмжээ авна: 3.1. Газрын тосны үйлдвэрийн хотхоны 1-р ээлжийн барилгуудыг ашиглалтад оруулж, төрийн өмчид бүртгүүлэх, ашиглалтад хяналт тавих, 3.2. Компанийн эзэмшлийн төмөр замын ашиглалт, арчлалт, хамгаалалттай холбогдолтой гэрээний хэрэгжилтэд хяналт тавих 3.3. МГТБҮ-ийн талбай дахь өмчийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулсан эсэхэд хяналт тавих	Компанийн эзэмшлийн эд хөрөнгийн арчлалт, хамгаалалт сайжирч, ашиглалтын үр ашиг нэмэгдсэн байх	ӨХЗ-ийн дарга, гишүүд ДБХГ СЭЗГ ГЭЗГ	Тухай бүр
4	Үйлдвэрийн хашаа болон дагалдах байгууллагуудыг төрийн өмчид бүртгүүлэх, эд хөрөнгийг жагсаалтад оруулах талаар ТӨБЗГ-т хүсэлт хүргүүлэх ажлыг зохион байгуулна.	Эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлж, өмчийн эзэмшигчээр бүртгүүлсэн байх	ӨХЗ-ийн дарга, гишүүд ДБХГ СЭЗГ	Тухай бүр

5	Хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх болон хөрөнгө хүлээн авах арга хэмжээ авах	Эрх бүхий байгууллагаар шийдвэрийг гаргуулж, хэрэгжүүлсэн байна.	ӨХЗ дарга, гишүүд	Тухай бүр
6	Эрсдэлээс урьдчилан сэргийлэх эд хөрөнгийг даатгалд хамруулах арга хэмжээ авсан эсэхэд хяналт тавьж, санал, зөвлөмж боловсруулах	Эрх бүхий байгууллагаар шийдвэрийг гаргуулж, хэрэгжүүлсэн байна.	ӨХЗ дарга, Гишүүд ГЭЗГ	Тухай бүр
7	“МГТБҮ” ТӨХХК-ийн бүртгэлд байгаа элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжгүй болсон, эвдэрсэн, устсан, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг актлуулах, данснаас хасах, зохих акт үйлдэх зэрэг арга хэмжээ авах	Эрх бүхий байгууллагаар шийдвэрийг гаргуулж, хэрэгжүүлсэн байна.	ӨХЗ дарга, гишүүд ГЭЗГ	Хагас, бүтэн жилээр
8	Компанийн эд хөрөнгийн иж бүрэн тооллогыг хийж хагас, бүтэн жилийн тооллогын дүнтэй танилцаж баталгаажуулах	ТӨБЗГ-ын 2020 оны 323 дугаар тогтоолын дагуу ажил гүйцэтгэсэн байна.	ӨХЗ дарга, гишүүд	Хагас, бүтэн жилээр

--- оОо ---